

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/07/НА-СТА-ТӨА

БАЯНЧАНДМАНЬ АЗЗА ТӨХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	19
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	20
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
АЗЗА	Авто зам засвар арчлалт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНЧАНДМАНЬ АЗЗА ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ

Б.МӨНХГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Доор дурдсан төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгоно.”, 4.1.6-д “Баянчандмань АЗЗА” ТӨХК гэж заасан байна.

Аудитын гол асуудал

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангаарх татварын өр төлбөрийн үлдэгдэл нийт богино хугацаат өр төлбөрийн 69,9 хувийг эзэлж байна. Энэ нь компанийн хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахаар байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 08 дугаар тогтоолоор Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн баталж, тайлант оны цэвэр ашгийн төлөвлөгөөг 38,864.0 мянган төгрөгөөр баталснаас 82,339.4 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, батлагдсан төлөвлөгөөг ханган биелүүлээгүй байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны онцгой үүрэг бүхий гэрээнд тусгагдсан 24 үүргийн биелэлтийг 89.4 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,731,962.82	55,434,785.21
1.1.4	Бусад авлага	27,705,730.33	17,798,544.93
1.1.6	Бараа материал	300,775,413.59	139,049,515.32
	Эргэлтийн хөрөнгийн дүн	332,213,106.74	212,282,845.46
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	729,213,775.17	729,709,116.27
1.2.2	Биет бус хөрөнгө	206,512,100.00	211,912,100.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	935,725,875.17	941,621,216.27
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,267,938,981.91	1,153,904,061.73
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	274,930,175.78	177,009,942.21
2.1.1.2	Цалингийн өглөг	1,763,423.02	-
2.1.1.3	Татварын өглөг	163,102,323.44	255,061,909.26
2.1.1.4	НДШ-ийн өглөг	177,754,099.04	155,982,595.45
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	617,550,021.28	588,054,446.92
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	207,952,733.00	207,952,733.00
2.1.2.3	Хойшлогдсон орлого	2,200,000.00	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	210,152,733.00	207,952,733.00
	Өр төлбөрийн нийт дүн	827,702,754.28	796,007,179.92
2.2	Эзэмшигчдийн өмч	946,003,905.78	946,003,905.78
2.2.1	Өмч: а) төрийн	-	-
2.2.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	119,574,539.03	119,574,539.03
2.2.3	Эздийн өмчийн бусад хэсэг	203,889,600.00	203,889,600.00
2.4	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(829,231,817.18)	(911,571,163.00)
	Эзэмшигчдийн өмчийн дүн	440,236,227.63	357,896,881.81
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,267,938,981.91	1,153,904,061.73

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	894,539,237.76	1,896,641,289.81
2	Борлуулалтын өртөг	790,148,174.19	1,640,403,407.09
3	Нийт ашиг (алдагдал)	104,391,063.57	256,237,882.72
5	Хүүгийн орлого	-	-
6	Бусад орлого	-	5,805,000.00
7	Ерөнхий ба удирдлагын зардал	286,010,517.53	327,562,620.54
8	Санхүүгийн зардал	-	-
9	Бусад зардал	3,232,593.37	16,819,608.00
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(184,852,047.33)	(82,339,345.82)
12	Орлогын татварын зардал / (буцаалт)	-	-
13	Татварын дараах ашиг (алдагдал)	(184,852,047.33)	(82,339,345.82)
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-
15	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
16	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
17	Орлогын нийт дүн	(184,852,047.33)	(82,339,345.82)
18	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	946,003,905.78	119,574,539.03	203,889,600.00	(644,379,769.85)	625,088,274.96
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	(184,852,047.33)	(184,852,047.33)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	946,003,905.78	119,574,539.03	203,889,600.00	(829,231,817.18)	440,236,227.63
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	(82,339,345.82)	(82,339,345.82)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	946,003,905.78	119,574,539.03	203,889,600.00	(911,571,163.00)	357,896,881.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,255,012,606.00	2,090,603,108.99
1.1.1	Бараа Борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	719,300,163.00	2,059,045,868.99
1.1.4	Бусад мөнгөн орлого /урьдчилж төлөгдсөн төлбөр/	535,712,443.00	31,557,240.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,243,864,786.59	1,937,082,859.93
1.2.1	Ажиллагчдад төлсөн	661,416,581.98	469,978,884.13
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	20,000,000.00	150,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	67,690,936.05	737,895,741.19
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	9,168,001.70	11,147,908.47
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн	385,023,430.54	424,367,760.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	75,012,700.00	61,899,638.78
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	191,250.00	1,579,895.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	25,361,886.32	80,213,032.36
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,147,819.41	153,520,249.06
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,343,253.18	101,817,426.67
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,343,253.18	95,877,426.67
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	5,940,000.00
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,343,253.18)	(101,817,426.67)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	141,614,700.00	109,600,400.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	141,614,700.00	109,600,400.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	141,614,700.00	109,600,400.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	141,614,700.00	109,600,400.00
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,195,433.77)	51,702,822.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,927,396.59	3,731,962.82
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,731,962.82	55,434,785.21

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2021 оны гүйцэтгэл	2022 оны төлөвлөгөө	2022 оны гүйцэтгэл	Хувь
1	Зам засвар, арчлалтын ажил	756,175.1	900,000.0	1,413,941.5	157.1
2	Машин механизмын түрээс, болон бусад орлого	138,364.1	200,000.0	488,504.8	244.3
Нийт орлогын дүн		894,539.2	1,100,000.0	1,902,446.3	172.9
1	Түүхий эд, материал	195,161.2	194,019.9	830,958.3	428.3
2	Тос тосолгоо	6,023.1	7,600.0	17,707.2	233.0
3	Шатахуун	115,613.3	108,000.0	212,778.2	197.0
4	Сэлбэг хэрэгсэл	15,766.0	19,690.0	58,286.6	296.0
5	Дулаан, халаалт	6,308.8	6,200.0	6,123.6	98.8
6	Цахилгаан	4,218.6	6,850.0	6,075.6	88.7
7	Тээвэр, бэлтгэл ажиллагаа	84,307.5	33,220.0	38,220.0	115.1
8	Хөдөлмөр хамгааллын зардал	4,996.0	9,890.0	17,669.0	178.7
9	Харуул хамгаалалт	920.0	1,000.0	1,000.0	100.0
10	Томилолт	20,100.6	25,300.0	41,127.0	162.6
11	Холбоо, бичиг хэрэг	2,991.2	3,180.0	6,642.8	208.9
12	Б. НӨАТ	859.0	2,100.0	3,062.4	145.8
13	Машин механизмын түрээс	80,775.8	58,600.0	66,625.9	113.7
14	Үндсэн хөрөнгийн элэгдэл	50,704.6	58,990.0	86,363.6	146.4
15	Үндсэн ба нэмэгдэл цалин	415,383.2	452,835.0	502,916.6	111.1
16	Нийгмийн даатгалын шимтгэл	64,246.3	65,661.1	72,409.2	110.3
17	Бусад зардал	11,016.0	8,000.0	16,819.7	210.2
Нийт зардлын дүн		1,079,391.2	1,061,136.0	1,984,785.6	187.0
Нийт ашиг		(184,852.0)	38,864.0	(82,339.4)	(211.9)
Цэвэр ашиг		-	34,977.6	(82,339.4)	(235.4)
Хөрөнгө оруулалт		-	102,433.2	94,033.3	91.8
1	Хүнд даацын автосамосвал / Хово /	-	60,000.0	54,454.5	90.8
2	Суурин компьютер	-	3,969.0	3,399.7	85.7
3	Өнгөт принтер	-	1,045.0	1,327.2	127.0
4	Суурин компьютер	-	3,875.3	3,354.3	86.6
5	Санхүүгийн программ	-	5,940.0	5,400.0	90.9
6	GPS	-	2,646.3	2,405.7	90.9
		-	825.0	750.0	90.9
7	Гар GPS	-	1,561.0	1,419.1	90.9
8	Зөөврийн сууц их засвар	-	10,571.7	9,562.8	90.5
9	Экскватор их засварт	-	12,000.0	11,960.0	99.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн зорилго нь: “Төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан “Зам засвар арчлалтын гэрээ”-ний дагуу Баянчандмань-Баруунхараа, Улаанбаатар-Лүн чиглэлд нийт 208 км замын хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй хангаж, ашгийн төлөө ажиллах”-д оршино.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн дүрэм, 2021/02/007 тоот тусгай зөвшөөрлөөр тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Таван км хүртэл хатуу хучилттай зам барих;
- Хайрган хучилттай зам барих;
- Бүх төрлийн зам гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил;
- Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах;
- Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил, үйлчилгээ эрхлэх ;

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, арчлалт, урсгал засварын ажлыг тогтмол гүйцэтгэх чиг үүрэг бүхий зам хариуцагч байгууллага байна. Зам хариуцагч байгууллага нь замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн болон хувийн өмчит хуулийн этгээд байна” гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг ЗТХЯ-ны харьяа байгууллага юм.

Компани 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлдэг.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн ТҮЗ-ийн 2019 оны 04 дүгээр тогтоолоор Төлөөлөн удирдах даргаар Зам, тээврийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ч.Ренчиндамбыг томилсон.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 83 дугаар тогтоолоор “Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн Р.Ширчиннямыг, 2022 оны 141 дүгээр тогтоолоор хараат бус 3 гишүүнийг тус тус дахин томилсон байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 08 дугаар тогтоолоор ТҮЗ-ийн дэргэдэх аудитын хороог 2, нэр дэвшүүлэх хороог 3, цалин урамшууллын хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 6 удаа зохион байгуулж, 10 асуудлуудыг хэлэлцэн баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн зардлыг 41,700.0 мянган төгрөгөөр баталж, цалинд 41,432.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай 2022 оны 16 дугаар тогтоол
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 03/01 дүгээр тушаалаар “Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг баталсан байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 07 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын нэгжийг шинэчлэн 3 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна. Дотоод хяналт шалгалтын нэгж нь 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 5 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан байна

Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын шалгалтаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 3,018.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг барагдуулаагүй байна.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 114,034.9 мянган төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,732.0	55,434.9	(51,702.8)
Авлага	27,705.7	17,798.5	9,907.2
Бараа материал	300,775.4	139,049.5	161,725.9
Үндсэн хөрөнгө	935,725.9	941,621.2	(5,895.3)
Нийт хөрөнгө	1,267,939.0	1,153,904.1	114,034.9
Өр төлбөр	827,702.8	796,007.2	31,695.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	440,236.2	357,896.9	82,339.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,267,939.0	1,153,904.1	114,034.9

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдэж, авлага, бараа материал, өр төлбөрийн данс буурсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 51,702.8 мянган төгрөгөөр өссөн тайлант оны эцэст ЗТХЯ-аас онцгой ажлын төлбөрийн санхүүжилт хийгдэж бүрэн зарцуулагдаагүй үлдсэн;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,895.3 мянган төгрөгөөр өссөн нь 94,033.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан;
- Авлагын дансны үлдэгдэл 9,907.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 2 байгууллагаас авах ажил үйлчилгээний төлбөрийн авлагыг барагдуулсан, НӨАТ-ын илүү төлөлтийг буцаан авсан;
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 31,695.6 мянган төгрөгөөр буурсан нь Наранбулаг хан ХХК-д төлөх асфальтын төлбөрийг төлж барагдуулсан;
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 82,339.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурсан нь гол нөлөөг үзүүлсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Баянчандмань АЗЗА ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 662 дугаар тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,100,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,061,136.0 мянган төгрөгөөр, 38,864.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 102,433.2 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,902,446.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,984,785.6 мянган төгрөгийн зардал гарган, 82,339.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,902,446.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 802,446.3 мянган төгрөг буюу 72.9 хувиар давсан нь зам засвар арчлалтын ажлын орлогын төлөвлөгөө 57,1 хувиар, машин механизмын түрээс, болон бусад ажлын орлогын төлөвлөгөө 2,4 дахин давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,984,785.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 923,647.7 мянган төгрөг буюу 87,0 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь үзүүлсэн үндсэн ажил үйлчилгээний хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор, орлогын хэмжээ 802,446.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 10 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 94,033.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант оны алдагдал 82,339.4 мянган төгрөг болж, 38,864.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ашгийн төлөвлөгөөг биелүүлээгүй нь өмнөх оны дуусаагүй үйлдвэрлэлийн 205,555.2 мянган төгрөгийн зардлыг тайлант онд үйлдвэрлэлийн зардалд бичсэн нь нөлөөлжээ.

ТӨБЗГ-т тайлант онд түрээсийн орлогын 40 хувь буюу 10,400.0 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Баянчандмань АЗЗА ТӨХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянчандмань АЗЗА ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 02 дүгээр сарын 09-ний өдрийн 36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **Дунд** гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,984,785.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19,847.9 мянган төгрөгөөр тогтоосны 70 хувиар гүйцэтгэлийн материаллаг байдлыг 13,893.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь цахилгаан, халаалт дулааны зардлыг хэмнэсэн боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагааны өсөлт, үнийн нэмэгдлээс шалтгаалан хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 183 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь байршуулж, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 9,763.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг 976,387.1 мянган төгрөгөөр буюу

966,623.3 мянган төгрөгөөр илүү, 4 удаагийн 33,230.4 мянган төгрөгийн орлого, 11 удаагийн 112,748.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, хөрөнгө, мөнгө зарцуулах 4 удаагийн 2,820.0 мянган төгрөгийн шийдвэрийн байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн тайланд завсрын аудитыг хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг “Гэрэлтэх бүртгэл Аудит” ХХК гүйцэтгэж, нийт 1,255,976.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 845.2 мянган төгрөгийн 1 акт, 10,114.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,245,016.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс 89,2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	845.2	1	845.2	100.0
Албан шаардлага	1	10,114.4	1	3,627.8	35.9
Зөвлөмж	3	1,245,016.8	1	1,115,422.1	89.6
Нийт дүн	5	1,255,976.4	3	1,119,895.1	89.2

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн яам, Кувейтын сангийн урт хугацаат зээлээр 2007 онд бэлтгэсэн тоног төхөөрөмжийн зээлийн үлдэгдлийг шийдвэрлэсэн байдал, заавар журмын дагуу илүү цагийн хөлсний тооцооллыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,850.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 16,850.8 мянган төгрөгийн алдааг залруулав.

- Үндсэн хөрөнгийн тодруулга дахь бусад зарлага 2,200.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэгдээгүй, дэлгэрэнгүй бүртгэл дэх 72,510.5 мянган орлогын дүн үндсэн хөрөнгийн тодруулгаас 1,432.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсаныг;
- Санхүүгийн тайлангийн тодруулгад худалдан авсан биет бус хөрөнгийг 8,555.7 мянган төгрөгөөр тайлагнасан нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 3,155.7 мянган төгрөгөөр илүү байгаа нь программ хангамжийн орлого 5,400.0 мянган төгрөгийн үнэнд GPS төхөөрөмж, хэрэгслийг үнэ 3,155.7 төгрөгийг нэмж биет бус хөрөнгөөр бүртгэснийг;
- Үндсэн хөрөнгийн тодруулга дахь худалдаж авсан үндсэн хөрөнгийн дүн нь мөнгөн гүйлгээний тайлангийн худалдан авсан үндсэн хөрөнгийн дүнгээс 10,062.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсаныг тус тус залруулав.

Аудитаар нийт 12,184.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 354.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 11,830.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд 4 ажилтны ээлжийн амралтын цалин хөлсийг тооцохдоо хоол унааны олговрыг дундаж цалин хөлсөнд оруулж тооцсоны улмаас 354.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 тоот тушаалын хавсралтын 3.3-т "Ээлжийн амралтын цалин бодох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал багтана." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Худалдан авсан хөрөнгө, материалын дүн, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 9 иргэн, байгууллагад 3,627.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Тайлант хугацаанд 2 байгууллагын 5,652.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 44.2.1.2-т "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасны үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Бэлэн мөнгөний кассаас эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй 50.0 мянган төгрөгийн шатахуун, 2,500.0 мянган төгрөгийн гэрээт ажлын хөлсийг анхан шатны баримтгүйгээр олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20 нэр төрлийн 255,419.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" НББОУС 16 -ын 31-д "Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүнийг дахин үнэлсэн дүнгээр бүртгэж тусгана. Энэ нь дахин үнэлгээний өдрөөрх хөрөнгийн бодит үнэ цэнээс дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба дараа үеийн хуримтлагдсан үнэ цэний бууралтын гарз юм. Тайлагналын үе бүрийн эцэс дэх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг ханган магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагад уламжлан холбогдох стандартын бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх.

2. Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн программ хангамж нь журнал тус бүрийн дүнг гаргах талаар бүрэн хөгжүүлэлт хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 47

дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3.4 дүгээр заалтыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн программ хангамж нийлүүлэгч байгууллагад хандах, холбогдох журам зааварт нийцүүлэн хөгжүүлэлт хийлгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дүгээр сарын 15 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тодруулга дахь бусад зарлага 2,200.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэгдээгүй, дэлгэрэнгүй бүртгэл дэх 72,510.5 мянган орлогын дүн үндсэн хөрөнгийн тодруулгаас 1,432.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан.	1	3,632.7			1	3,632.7	1	3,632.7				
Санхүүгийн тайлангийн тодруулгад худалдан авсан биет бус хөрөнгийг 8,555.7 мянган төгрөгөөр тайлагнасан нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 3,155.7 мянган төгрөгөөр илүү байгаа нь программ хангамжийн орлого 5,400.0 мянган төгрөгийн үнэнд GPS төхөөрөмж, хэрэгслийг үнэ 3,155.7 төгрөгийг нэмж биет бус хөрөнгөөр бүртгэснээс шалтгаалсан байна.	1	3,155.7			1	3,155.7	1	3,155.7				
Үндсэн хөрөнгийн тодруулга дахь худалдаж авсан үндсэн хөрөнгийн дүн нь мөнгөн гүйлгээний тайлангийн худалдан авсан үндсэн хөрөнгийн дүнгээс 10,062.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан байна.	1	10,062.4			1	10,062.4	1	10,062.4				
Дүн	3	16,850.8	0	0	3	16,850.8	3	16,850.8	0	0	0	0

**Баянчандмань АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан**

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 4 ажилтны ээлжийн амралтын цалин хөлсийг тооцохдоо хоол унааны олговрыг дундаж цалин хөлсөнд оруулж тооцсоноос 354.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	354.0	1	354.0								
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн , бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 9 иргэн, байгууллагад 3,627.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.	1	3,627.80			1	3,627.80						
Тайлант хугацаанд 2 байгууллагын 5,652.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	5,652.9			1	5,652.9						
Бэлэн мөнгөний кассаас эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй 50.0 мянган төгрөгийн шатахууныг, 2,500.0 мянган төгрөгийн гэрээт ажлын хөлсийг анхан шатны баримтгүйгээр олгосон байна.	1	2,550.0			1	2,550.0						
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20 нэр төрлийн 255,419.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй байна.	1	-					1	-				
Санхүүгийн программ хангамж нь журнал тус бүрийн дүнг гаргах талаар бүрэн хөгжүүлэлт хийгдээгүй байна.	1						1	-				
Дүн	6	12,184.7	1	354.0	3	11,830.7	2	-				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 183 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь байршуулж, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 9,763.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг 976,387.1 мянган төгрөгөөр буюу 966,623.3 мянган төгрөгөөр илүү, 4 удаагийн 33,230.4 мянган төгрөгийн орлого, 11 удаагийн 112,748.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, ... хөрөнгө, мөнгө зарцуулах 4 удаагийн 2,820.0 мянган төгрөгийн шийдвэрийн байршуулаагүй байна.	1	1,115,422.1			1	1,115,422.1		
Дүн	1	1,115,422.1	0	0	1	1,115,422.1		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	11	1,144,457.6			1	1,144,103.6		